

*Б.Монхтулга- Хууль сахиулахын удирдлагын  
академийн 8052 дугаар дамжааны суралцагч*

## **ХОРИХ АНГИД ҮҮСЧ БОЛЗОШГҮЙ ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫН ОЙЛГОЛТ, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС**

***Хураангуй.** Энэхүү илтгэлээр эмх замбараагүй байдлын тухай ойлголт,  
нөлөөлөх хүчин зүйлсийн зарим асуудлын талаар гаргаж тавихыг зорилоо.*

***Түлхүүр** үг. Эмх замбараагүй байдал, Нийтийн хэв журмыг бүлэглэн  
зорчих. Нийтийг хамарсан үймээн.*

Манай улс дэлхийн улс орнуудтай харьцуулахад хүний эрх, эрх чөлөөг хязалаарлах, иргэдийн амь бие, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд халдаж болох аюулгүй байдлын хүрээ, олон нийтийн эмх замбараагүй байдал бий болох улс төр, эдийн засгийн үндэслэл бага, харьцангуй тайван орны нэг.<sup>1</sup>

Иргэдийн тайван замаар жагсаал цуглаан хийх эрхийг ашиглан зөвшөөрөгдсөн газарт, хуулийн дагуу явуулахгүй хууль зөрчих, улс төр хийх, бусдыг хууль бус халдлагад өдөөн турхирах, бусдын болон төрийн тангараг өргөсөн алба хаагчдын эрх чөлөөнд халдах, бусдын болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэн гэмтээх, устгах, шатаах, иргэдийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөөнд бүдүүлгээр халдах, хууль бусаар халдах, олон нийтийн зорчих хэсгийг хаах, төрийн тусгай хамгаалалтын бүсэд дур зоргоор нэвтэрч танхайрах зэрэг нийгмийн гажууд үзэгдэл сүүлийн үед гарсаар байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын тухай ойлголт нь нийгмийн хэв журам, нийтийн хэв журамтай салшгүй холбоотой билээ.

Нийтийг хамарсан үймээн. Энэ нь эмх замбараа алдагдан, дэг журам зөрчигдөж, үйлдвэр, албан газар, байгууллагын хэвийн үйл ажиллагааг саатуулах төдийгүй, иргэд бэртэж гэмтэх, эд хөрөнгө эвдэрч сүйтгэх зэрэгт бусад ноцтой үйлдэл дагалдан гардаг тул үлэмж их хор аюултай.<sup>1 2</sup> Нийтийн хэв журам алдагдвал нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх нэг хүчин зүйл болно.

Нийтийн хэв журам хамгаалах нь олон нийтийн газарт бүх нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг сахиулах, нөгөө талаар уг журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах, түүнчлэн эрх ашиг нь зөрчигдсөн тохиолдолд эрхийг нь хангах явдлаар илэрнэ.

<sup>1</sup> Л. Билгээ. Цагдаагийн үйл ажиллагааны арга зүйн зарим асуудлууд. УБ. 2009. 94 дэх тал

<sup>2</sup> Д. Таванжин. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2006. 237 дахь тал

Нийтийн хэв журам бүлэглэн зөрчих, нийтийг хамарсан үймээн гаргах явдлаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох ажиллагаа нь Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргүүдийн нэг билээ.

Нийтийн хэв журам алдагдуулсан үйл явдлыг цар хүрээнээс нь хамаарч 2 ангилж болно.

® Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчих. Энэ нь нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг илтээр эсэргүүцэж, шаардлага тавих, хүч хэрэглэх байдлаар илэрч байгаа үйлдэл байна. Үүнийг гарсан дор нь таслан зогсоохгүй бол цаашдаа даамжран нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд хүргэж болзошгүй нөхцөл байдал үүсч болдогоороо бүлэглэн танхайрах явдалтай харьцуулбал нийгмийн хор аюулаараа их бөгөөд гарах үр дагавар нь аюултай юм.

д Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал. Энэ нь нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам үйлчлэхгүй, хууль сахиулах үүрэг бүхий байгууллага ердийн арга хэрэгслээр хэвийн байдалд оруулах боломжгүй болсон, дэг журам болон аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, иргэд, олон нийт бэртэж, гэмтэх, эд хөрөнгө эвдэж сүйтгэх зэрэг бусад ноцтой үйлдэл дагалдан гардаг тул гарах үр дагавар нь нийгэмд асар их хор уршиг дагуулдаг аюул юм.

Эмх замбараагүй байдлын талаар эрдэмтэн, судлаачид янз бүрээр тайлбарласан байдаг. Тухайлбал, академич С.Нарангэрэл “Нийтийн эмх замбараагүй байдал буй болгох нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 179-р зүйлд заасан нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. Энэхүү гэмт хэргийн объектив тал нь түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчдийг зэвсэглэн эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан, өдөөн турхирсанаар илэрнэ” хэмээн тодорхойлсон бол судлаач О.Самбуу “Хэсэг бүлгээрээ хамтарч нийгмийн хэв журам зөрчигдсөнөөр зөрчигчдийн тоо эрс өсөж уг үйлдэл нь бусдад захирагдахгүйгээр өөрсдийн дур зоргоор онцгой танхай шинж чанарыг агуулсан байхыг нийтийг эмх замбараагүй байдал гэнэ гэж тодорхойлсон байна.

Эмх замбараагүй байдал нь хорих анги /салбар/-д үүсч болзошгүй нийгмийн аюулт үзэгдлийн нэг юм.

Хорих анги салбарт нийтийн эмх замбараагүй байдал нь дараах хэлбэрээр илрэн гарч болно. Үүнд:

1. Ялтнууд хэсэг бүлгээрээ нийлж өлсгөлөн зарлах;
2. Ялтнууд хэсэг бүлгээрээ нийлж суулт зохион байгуулах;
3. Нөлөө бүхий ялтнууд хоорондоо хагаралдан зөрчил үүсгэх, уг зөрчил нь олон нийтийг хамарсан шинжтэй болох;

4. олны танил хүмүүс буюу дуулиант хэрэгт шийтгэгдсэн /улс төрийн, нөлөө бүхий /ялтнуудыг суллах зорилгоор хорих ангийн харуул хамгаалалтанд гаднаас халдах, жагсаал цуглаан зохион байгуулах;
5. Байгалийн гаралтай ган, зуд, гал түймэр, газар хөдлөлт болсон үед;

Дээрх хорих ангид бий болж болзошгүй нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын илрэх хэлбэрийг тус бүрд нь авч үзье.

Ялтнууд хэсэг бүлгээрээ нийлж өлсгөлөн зарлах:

Хорих анги /салбар/-д ял эдэлж байгаа ялтнууд хорих байгууллагын ял эдлүүлэх үйл ажиллагааг эсэргүүцэн хэсэг бүлгээрээ нийлж өлсгөлөн зарлах явдал гардаг. Нэг буюу хэсэг бҮлэг хҮмйс байгууллага, аж ахуйн нэгж, гэр, байр, гудамж талбайд тннчлэн хорих анги, цагдан хорих, баривчлах байранд өлсгөлөн зарласан 1'ед эмнэлгийн тусламж үзүүлэх, цагдаа болон хорих байгууллагаас эмнэлгийн байгууллагын ажилтны аюулпй байдлыг хангахтай холбогдсон харилцааг “Өлсгөлөн заралсан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар”[8.1] -ын дагуу зохион байгуулдаг.

Хорих ангийн зүгээс өлсгөлөн заралсан этгээдүүдийг тусгаарлан эмнэлгийн эмчийн үзлэгээр оруулах, өлсгөлөн зарлагч этгээдүүд болон эмнэлгийн байгууллагын ажилтан, эмч нарын аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээнэ.

Ялтнууд хэсэг бүлгээрээ нийлж суулт зохион байгуулах:

Ялтнууд хэсэг бүлгээрээ суулт зохион байгуулах нь асуудал нь хорих байгууллагад тулгамдаж байгаа асуудлын нэг юм.

Хорих анги /салбар/-т ял эдэлж байгаа ялтнууд хорих ангиас явуулж байгаа үйл ажиллагаа, дээд байгууллагаас гаргасан аливаа нэг шийдвэрийг эсэргүүцэн хэсэг бүлгээрээ нийлж суулт хийн хорих байгууллагын захиргаанд захирагдахгүй байхыг хэлнэ. Суулт нь өлсгөлөнгөөс онцлогтой ба зорилго нь нэг байж болно. Суултад хамрагдсан ялтнууд хоол, ундаа чөлөөтэй иддэгээрээ онцлог байдаг.

Хорих байгууллагад түүхийн хугацаанд хорих ангид ял эдэлж байгаа ялтнуудын зүгээс зохион байгуулалттай олон нийтийг хамарсан суулт зохион байгуулсан хэд хэдэн тохиолдол гарсан байдаг.

1999 онд Авдрант дахь хорих 403 дугаар ангийн онцгой дэглэмтэй 80 орчим ялтан зохион байгуулалттайгаар “...онцгой дэглэмтэй ялтнууд хуулийн тэгшитгэлд хамрагдаагүй. Энэ асуудлыг шийдэж өгөх хүртэл суултаа дуусгахгүй...” гэх шаардлага тавин суулт зохион байгуулсан байдаг.

Энэ үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар тус хорих ангид “Хүчлэн хамгаалалт зарлан” ялтны зүгээс гаргасан шаардлагыг холбогдох албан тушаалтан, байгууллагад хүргүүлсэн ба үүний дагуу УИХ-ын гишүүн

Г.Хувьтөгөлдөр ирж нийт суулт хийсэн ялтнуудтай уулзан суултыг зогсоосон. Мөн улмаар 2009 онд "Өршөөл үзүүлэх тухай хууль" гарсны дараа буюу 2009 оны 07 дугаар сарын 24-нд Булган аймаг дахь онцгой дэглэмтэй хорих 439 дүгээр ангийн 60 ялтан "Өршөөлийн хуульд хамрагдаагүй, цаашид хамруулж өгтөл суултаа хийнэ" гэсэн шаардлагыг тавин суулт хийсэн.

Мөн энэ үед тус ангийн харуул хамгаалалтын нөхцөл байдал маш их хүндэрсэн ба тухайн үед 80 ялтантай 1 амьдралын бүсэд 3 хянагч л үүрэг гүйцэтгэдэг байсан. Хорих ангийн зүгээс тавьсан шаардлагыг хүлээж аваагүй ба ямар нэгэн байдлаар албан хаагчдаас уг асуудлыг таслан зогсоох зорилгоор хүч хэрэглэсэн тохиолдолд ялтны зүгээс ямар ч асуудал гарахад бэлэн болчихсон нөхцөл байдал хүндэрсэн байсан юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас уг гарсан нөхцөл байдалд дүгнэлт хийж гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал:

ШШГЕГ-ын тусгай бүлгийн албан хаагчдыг Булган аймаг дахь хорих 439 дүгээр анги руу гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хүч нэмэгдүүлэн явуулж байнгын бэлэн байдалд байлгасан;

Хорих ангийн зүгээс харуул хамгаалалтын хүчийг нэмэгдүүлэн, нийгмийн ажлын албанаас суулт хийж буй ялтнуудын сэтгэл санаанд нөлөөлөх сэтгэл зүйн арга хэмжээг зохион байгуулсан /яриа, таниулга, гарч болзошгүй аюул, гарах үр дагавар/;

Хорих ангийн гүйцэтгэх алба гүйцэтгэх албаны шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулан түүнд дүгнэлт хийн суулт зохион байгуулагч этгээдүүдийг илрүүлэх, тэдэнд гүйцэтгэх ажлын шугмаар нөлөөлөх арга хэмжээнүүдийг тус тус авч хэрэгжүүлж ажилласан ба 7 хоногийн дараа уг суултыг таслан зогсоосон байна.

Нөлөө бүхий ялтнууд хоорондоо хагаралдан зөрчил үүсгэх, уг зөрчил нь олон нийтийг хамарсан шинжтэй болох:

Хорих анги /салбар/-т ял эдэлж байгаа ялтнууд нь хорих ангийн байрлалд байрандаа 1 өрөөнд 8 ялтан байралдаг. Хаана, хэн гэдэг ялтан байрлахыг хорих ангийн төлөөлөгч, нийгмийн ажилтан нар гаргаж гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд даргад танилцуулан шийдвэрдэг. Гэсэн хэдий ч ял эдэлж байгаа ялтнуудын зүгээс санаа зорилго нийлсэн, нэг нутгийн аль эсвэл нэг хэрэгт хамт шийдэгдсэнээрээ нийлэн гал буюу бүлэглэл заавал аль ч хорих ангид үүсдэг юм.

Эдгээр бүлэглэлүүдийн хооронд зөрчил үүсэн нийтийг хамарсан шинжтэй болж олон хүн хохирох, харуул хамгаалалтанд хүндрэл учруулах тохиолдол гардаг.

Олны танил хүмүүс буюу дуулиант хэрэгт шийтгэгдсэн ялтнуудыг суллах зорилгоор хорих ангийн харуул хамгаалалтанд гаднаас халдах, жагсаал цуглаан зохион байгуулах:

Монгол улсын Үндсэн хуульд зааснаар “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, пгүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан байдаг. Энэ нь албан тушаал, цол зэрэг, баян хоосон, яс үндэс, шашин шүтлэгээр ялагдгүйгээр хууль, шүүхийн өмнө тэгш эрх эдэлнэ гэсэн үг юм.

Хэргийн улмаас шүүхийн шийтгэх тогтоолоор шийтгүүлэн хорих ангид ял эдлэхээр ирсэн олны танил буюу дуулиант хэрэгт шийтгэгдсэн ялтнууд нь хорих ангийн албан хаагчийн тавьсан шаардлагыг эсэргүүцэх, шаардлагад захирагдахгүй байх, хэрэг хийснээ хүлээн зөвшөөрөхгүй байх үйлдлүүдийг гарган хорих ангийн харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги албадын гадна харуул хамгаалалтанд ямар нэгэн байдлаар гаднаас халдсан тохиолдолд тухайн хорих ангид түүнийг зогсоох хүч хэрэгсэл байхгүй, зөвхөн ээлжийн бүрэлдэхүүн л уурэг гүйцэтгэдэг ба цаашид хорих ангид байнгын бэлэн байдалд байдаг тодорхой зэвсэглэлтэй шуурхай бүлэг харуул хамгаалалтандаа ашиглах нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр дээрх аюулуудаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шуурхай арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ.

Байгалийн гаралтай ган, зуд, гал түймэр, газар хөдлөлт болсон үед:

Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл нь хорих байгууллагын барилга, байгууламж, объект, албан хаагч, ялтанд хор хохирол учруулахаас гадна сэжигтэн, яллагдагч, ялтны зүгээс тухайн гамшиг, аюулт үзэгдлийг далимдуулан оргох, бусдын бие махбодь, эд хөрөнгөнд хохирол учруулах, бусдыг барьцаанд авах, хорих ангийн бүсэд эмх замбараагүй байдал, үймээн самуун дэгдээх зэрэг хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, улмаар нийгэм ард, иргэдэд ноцтой хор хохирол учруулах магадлалтай байдаг.

Хорих анги байгалийн гамшиг, аюулт үзэгдэлд өртөх тохиодол олон байдаг. Байгалийн гамшигийн төрлүүдээс хорих ангид гал түймэр, газар хөдлөлт, үер, болон техникийн гаралтай ослоуд тохиолдож болно. 2017 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 249 дүгээр зүйлд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга 30 хүртэл хоногийн хугацаагаар онцгой дэглэм тогтоон, Улсын ерөнхий прокурорт даруй мэдэгдэнэ. Хорих ангид тогтоосон онцгой дэглэмийг түүнийг тогтоосон албан тушаалтан цуцлах бөгөөд эмх замбараагүй байдал, түүний хор уршиг арилаагүй тохиолдолд 30 хүртэл хоногоор сунгаж болно.

Хорих ангид онцгой дэглэм тогтоосон үед хоригдлын оролцоотой зохион байгуулагддаг бүх ажиллагааг зогсоох бөгөөд хорих ангийн өндөржүүлсэн

бэлэн байдлын зэргийг нэмэгдүүлж, эргэлт, уулзалт, захидал харилцааг хориглох. хорих ангийн өдрийн цагийн хуваарийг өөрчилж болдог байна.

### Дүгнэлт. санал:

Хорих ангид эмх замбараагүй байдал бий болох нь хүний болон хүний хүчнээс үл шалтгаалан үүсч бий болсон хорих ял эдлүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчсөн, хор уршиг нь хорих ангийн хэвийн үйл ажиллагаа, хүний амь бие. эрүүл мэнд, эд хөрөнгөд асар их хохирол уршиг учруулж болохуйц хоригдлын зүгээс гаргаж буй үйлдэл юм. Хорих ангид үүсч бий болзошгүй эмх замбараагүй байдлыг тодорхойлсноороо түүнээс урьдчилан сэргийлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авах ач холбогдолтой юм. Судалгааны явцад дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1 .Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад эмх замбараагүй байдлын тодорхойлолт, илрэн гарах хэлбэрийг зөв, оновчтой тодорхойлох нь онол, практикийн хувьд чухал байна.

2 .Хууль сахиулах салбарын байгууллагуудад хорих ангид үүсч болзошгүй эмх замбараагүй байдлын үед ажиллах төлөвлөгөө, арга тактикийн сургалтыг тогтмолжуулж байх.

3 . ШШГЕГ болон удирдах албан тушаалтнууд харилцан ажилладаг байгууллагуудтайгаа жилд 2-оос доошгүй удаа хорих ангид эмх замбараагүй байдал үүсэх үед хамтын ажиллагааны талаарх сэдвийн доор явуулж байх нь үр дүнтэй гэж үзэж байна.